

Хөрөнгө оруулалтын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1а, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 41.1.4, Монгол Улсын Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн төсвийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн газар, зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зэрэг бэлтгэл ажлыг нэгдүгээр улиралд багтаан хангах, холбогдох хуульд заасан захиалагчийн эрх үүргийг хэрэгжүүлж мэргэжлийн байгууллагатай хамтран захиалагчийн хяналт тавих, хөрөнгө оруулалтаар бий болсон өмч хөрөнгийг харьяалагдах байгууллагын өмчлөлд бүртгүүлэх зэрэг ажлуудыг хариуцан зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

2. Хөрөнгө оруулалтын ажлыг хариуцан ажиллах, хамтран хэрэгжүүлэх хэлтэс, албадын ажил үүргийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журамд нийцүүлэн шуурхай, үр ашигтай зохион байгуулах, олон нийтэд мэдээллийг ил тод нээлттэй хүргэх зэрэг ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Худалдан авах ажиллагааны алба /С.Жамъяндорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ